

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 20-ны өдөр

Дугаар 69 - 081/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 20 (хорь) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 225 (хоёр зуун хорин тав) айлын хүчин чадалтай орон сууц зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 21-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2025/12/10 огноо, 0000120, БАЗГ2023/575 дугаар
- 2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ЕГ шифр: S&V-02/2023, ТГ Шифр: АС 23/02
- 2.3 Захиалагч: Хандгайтын богино ХХК оноосон нэр, 9011443109 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2820536 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 15-р хороо, Хандгайтын богино, Өөрийн байр 88110625, 99112897 холбоо барих утас, khandgaitiinbogino@gmail.com цахим хаяг
Захиалагч: Иргэн Шонх овог, Балдорж эцэг эхийн нэр, Лхагвасүрэн өөрийн нэр, УИ97092457 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, 126-1001 тоот, 88110625 холбоо барих утас;
- 2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Ньюплан ХХК оноосон нэр, 9011153132 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5244595 регистрийн дугаар, БУ11-652/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 13-р хороо, 3-р хороолол, Оффис центр-1 давхар 88999097 холбоо барих утас, newplan_mgl@yahoo.com цахим хаяг;
- 2.5 Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй. ГАЗАР
- 2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: АРХЖС ХХК оноосон нэр, 9011217024 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5342708 регистрийн дугаар, 3Т17-873/24 зураг төсөл боловсруулах тусгай

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтад
орлуулах комисс

зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р дугаар хороо, Манлай баатар Дамдинсүрэнгийн гудамж. UB tower Plus 905 тоот, 89100817, 77740040 холбоо барих утас, alfaskybuildingllc@gmail.com цахим хаяг;

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: 2117118 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу Өөрийн байр, ХҮТ-17 Ахлах инженер Г. Сүхжаргал 88991122 холбоо барих утас, g.svhjargal0220@gmail.com цахим хаяг;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул


- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, , 20 (хорь) автомашины дулаан зогсоолтой, 225 (хоёр зуун хорин тав) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууц зориулалттай барилга байгууламжид түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.



3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 38 рхуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 20 (хорь) автомашины дулаан зогсоолтой, 225 (хоёр зуун хорин тав) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууц зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Хандгайтын богино ХХК, Иргэн Б.Лхагвасүрэнгийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 20 (хорь) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 225 (хоёр зуун хорин тав) айлын орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Захиалагч иргэн


(Б.Лхагвасүрэн)

Хандгайтын богино ХХК-ийн гүйцэтгэх захирал



(Б.Лхагвасүрэн)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРОО, ХАНДГАЙТЫН БОГИНО ХХК,
ИРГЭН Б.ЛХАГВАСҮРЭНГИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 16 ДАВХАР 1
БЛОК, 20 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 225
АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Хандгайтын богино ХХК, Иргэн Б.Лхагвасүрэнгийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 20 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 225 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхарт 2025 оны 02 дугаар сарын 21-ны өдөр 13 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14:50 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч 3.Ганбат
3. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Э.Цогзолмаа
4. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер Б.Оргил
5. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.Даваадэмид
6. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх албаны менежер Д.Болормаа
7. Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа М.Батсайхан
8. Үндэсний Төв Архив, Ахлах архивч Б. Оюунжаргал
9. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн О.Ундрах
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Хүртээмжийн үнэлгээний ажилтан Н.Эрдэнэтөгс
11. Ашиглалт хариуцах байгууллага ОСНААУГ-ийн ХҮТ-1, Ахлах инженер Б.Уранцэцэг
12. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч иргэн Б.Лхагвасүрэн
13. Зураг төсөл зохиогч байгууллага: “АРХЖС” ХХК-ийн гүйцэтгэх захирал В. Баасанбаатар
14. Барилгын ажил гүйцэтгэгч

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 14
- Хүрэлцэн ирсэн – 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Хандгайтын богино ХХК, Иргэн Б.Лхагвасүрэнгийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 20 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 225 айлын орон сууцны барилга байгууламжийн ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **З.Ганбат:**

- Техникийн давхрын өөрчлөлтийн талаар зураг төсөл зохиогч автор тайлбар ирүүлэх /барилга бүтээц тайлбар/
- Дулааны магистрал шугамтай холбоотой ерөнхий төлөвлөлтийн зургын өөрчлөлтийг АРХЖС ххк өөрөө гаргаад түүний дагуу гүйцэтгэх түүний талаар тайлбар ирүүлэх Стийл ллайн ХХК зургийг хүчингүйд тооцох
- Ерөнхий төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийн зургийг автор баталгаажуулж, ХБХСГ-аар зөвшилцөх
- “БАТДАХ”ХХК-с тайлбар бичиг авч, гэрээг дүгнэн ирүүлэх
- Дутуу ажил дуусгах хугацаа заасан албан бичиг ирүүлэх
- Цаашид Барилгын баримт бичгийг “Хандгайтын богино”ХХК-р болгож хүлээлгэж өгөх
- Бетоны бат бэхийн шинжилгээний сорьц үзүүлэх
- Гадна зогсоолыг нэмэгдүүлэх талаар албан бичиг өгч ерөнхий төлөвлөгөөнд тусгах
- Хог төвлөрүүлэх зайлуулах цэг байршуулах
- Хүүхдийн тоглоомын талбайг өөр газарт байгуулах тусгаж баталгаа ирүүлнэ
- 30% ногоон байгууламж хаана хийх талаар өөрчлөлтийн зурагт оруулж баталгаа өгөх
- Грашын трапны ус зайлуулах шугамыг шинэчлэн янзалж хийнэ, пандусны дээр хаалт хийнэ
- Техникийн давхарт оршин суух зориулалтаар ашиглахгүй байх баталгаа ирүүлэх, өөрчлөлтийн зурагт хавсаргах
- Зургийн өөрчлөлтүүдийг дахин хийх нэгдсэн дүгнэлтэнд тусгах
- Хүүхэд хөгжлийн төв, өдөр өнжүүлэх төв хараар хүлээж авна гэсэн баталгаа өгөх

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**:

- Гадна дулааны худгийн цэвэрлэгээ хийх засвар үйлчилгээ хийх фото зургаар баталгаажуулах, тайлбар албан бичиг ирүүлэх
- Узелийн өрөөний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг хаягжуулах , угсралтын ажлыг бүрэн дуусгах
- В1 давхарын АС-н угсралтын ажлыг дуусгаж хэвийн ажиллагаанд оруулах, баталгаа албан тоот ирүүлэх
- 1-р давхарын үйлчилгээний барилгын АС-г угсралтыг бүрэн дуусгах баталгаа албан тоот ирүүлэх
- Айл өрхийн агааржуулалтын сорох хэсгийн решотканы байрлалыг сольж фото зургаар баталгаажуулах
- Дулааны узель халаалтын систем угсралтын компани ашиглагч нар зүгшрүүлэх, тохируулгаын баталгаа албан бичиг ирүүлэх
- Коридорын коллекторыг цэвэрлэж, усны тоолуурыг хаягжуулах

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Зүүн түгээх төв, Ахлах инженер **Б.Оргил**:

- Дараагын блокын техникийн нөхцөл авахдаа хэрэгцээний халуун усны нийлбэр ачааллыг тооцох
- Гадны дулааны шугам, мэдээллийн санд өгөх, акт шалгуулах
- Гадна худгийн тагийг бэхлэх
- Хаягжуулалт хийж дулааны узелийн дулаалга сайжруулах
- Зуны улиралд болон горим ажиллагаа доголдсон үед ашиглах хэрэгцээний халуун усны нэмэлт эх үүсвэр угсрах/ Зураг техникийн нөхцөлийн дагуу/
- Гадна дулааны шугам, халаалт агаар сэлгэлтийн өөрчлөлтийн зураг батлуулж нийслэлийн мэдээллийн санд болон архивт өгөх
- Дотор халаалтын системд термостат вентэль угсрах, коллекторууд дээр хаягжуулалт хийх, халаалтын дотоод тохируулга хийх

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид**:

- Зоорийн давхарт холбооны техникийн өрөөг зургийн дагуу гүйцэтгэх
- Кабель шугамын тавиур хаягжуулах
- Давхарын самбар кабель шугамыг цэгцлэн бэхлэх, бирк зүүн хаягжуулах, самбарыг хаягжуулах
- Домофон системийн ажлыг бүрэн хийж дуусгах
- Камерын ажлыг бүрэн хийж дуусгах /фото зургаар/
- Галын системийн утаа мэдрэгчүүдийг бүрэн ажилд оруулах
- Зарлан мэдээллэх системийг бүрэн зургийн дагуу ажилд оруулах

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх албаны менежер **Д.Болормаа**:

- Ундны усны нөөцийн савыг батлагдсан ажлыг зургийн дагуу 78м3 суурилуулах
- Ундны усны нөөцийн саванд засвар үйлчилгээ хийх боломжгүй угсарсан байна.Таазтай ойр хүн орох боломжгүй байна.Боломжтой болгох

- Ундны усыг шинжилгээнд өгч дүгнэлт гаргуулах/Нийслэлийн эрүүл мэндийн газарт/
- Иргэн Энхмэнд нартай зөвшилцсөн ил далд ажилын акт үзүүлэх
- БУХ-н стандартын дагуу модон таш суурилуулах
- ЦУХ-г битеррит сайжруулах

Онцгой байдлын ерөнхий газар, барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа **М.Батсайхан**:

- Зоорийн давхарт буусан цахилгаан шатны өмнө хаалт хийх
- ГК хэвийн болгох
- Гал унтраах спинклерийн систем хэвийн болгох
- Шатны хонгил хаалганд өөрөө хаагч тоноглол хийх
- Усны нөөцийн сав багассан, өрөөг хааж өрлөг хийх тайлбар бичиг өгөх
- Зогсоолыг дугаарлаж, хэвтээ босоо тэмдэглэгээ хийх
- Зоорийн давхрын агаар сэлгэлтийн систем ажилд оруулах
- Гадна хананы гал тэсвэржилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх
- Өөрчлөлтийн зураг хянуулах
- Техникийн давхарт галын дохиолол мэдээллэгч хийх, норм дүрмийн дагуу ашиглах баталгаа албан бичиг өгөх
- Шаталтын бүтээгдэхүүн сорох системийн хаях хэсгийг 2м болгох
- Утаа сорох, даралттай агаар өгөх системийн автоматжуулалт хийх
- Галын дохиолол мэдээллэгчийг хэвийн ажилд оруулах хүлээн авах станцыг хүн 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах
- 1-р давхарын шатны хонгилын хаалгыг гарах чиглэлд нээгдэхээр болгох

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах**:

- 16 давхарын тагтны дээврийн ажлыг хийх тагтны гадна заслыг хийх
- Техникийн давхарын болон үйлчилгээний хэсгийн заслын туу ажлыг бүрэн дуусгах
- Өөрчлөлтийн зургийг эрх бүхий байгууллагуудаар батлуулах
- Сууриас 16 давхар хүртэл бетоны бат бэхийг хөндлөнгийн байгууллагаар дүгнэлт гаргуулсан лаборторын дүгнэлт, пандусанд хамгаалалтын хашлага хайс хийх
- Норм нормативын төлбөрийг тооцуулж төлөх Барилгын тухай хуулийн 5,71-д заасны дагуу
- Шатны хонгилын 1-р давхарын хаалгыг зураг төслийн дагуу гадагшаа онгойлттой болгох

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний Төв Архив, Ахлах архивч **Б.Оюунжаргал**:

- Хувийн хэргийг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй хүлээлгэн өгөх, дотоод товёог хийх

- Архивд баримтаа баримт бүрдүүлэх нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй хүлээлгэн өгөх
- БҮ-н далд ажлын акт, гэрэл зургийг ажлын үе шатаар дарааллан эх хувиар дотоод товъёог хийж өгөх
- БҮ-н тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулж ажлын нэрээр гарчиглаж өгөх
- Барилгад хэрэглэсэн бараа материал, лабораторын шинжилгээний дүн, чанарын гэрчилгээг дотоод товъёог хийж бүрэн өгөх
- Ажлын болон өөрчлөлтийн зургийг бүрэн баталгаажуулан эх хувиар нүүр хуудас жигд дугаарлан өгөх
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтэнд холбогдох баримтыг хувийн хэрэгт хавсаргах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл
Н.Эрдэнэтөгс:

- Гаднах дутуу ажлуудаа гүйцэтгээд явган хүний замыг стандартын дагуу хийх, мөн бродюруудад налуулага хийх
- Гадна үүдний довжооны налуу замыг батлагдсан зургийн дагуу налуулгыг мөн бариулыг бариул хоорондын зайг стандартын дагуу хийх
- Гаднаас орох төв хаалгануудыг зургийн дагуу болгож солих
- Үйлчилгээний хэсгийн 00дад ХБИ –н тоноглол суулгах

Ашиглалт хариуцах байгууллага ОСНААУГ-ийн ХҮТ-1, Ахлах инженер
Б.Уранцэцэг:

- Хүйтэн усны нөөцийн саванд хяналт тавьж цэвэрлэгээ үйлчилгээ хийх боломжтой болгох
- Узелийн автомат удирдлагын самбар ажиллагаанд оруулах
- Узелийн тоног төхөөрөмж дээр хэмжих хэрэгсэл бүрэн суурилуулах
- Узелийн цахилгааны хэрэгсэл дээр тоолуур тавих
- Узелийн хаягжуулалт хийх
- Айл өрхийн дотор явж байгаа бохирын шугам далдлах
- Айл өрхийн шугамд босоо хяналтын цонх бүрэн хийх
- Усны тоолууранд хэрэглэгчийн тоотыг тавих
- Зоорийн давхрын бохирын шугамд хяналтын трап хийх
- Зоорийн давхарын хэвтээ шугамын аваарын хаалтууд ил хийх
- Гадна бохирын худаг цэвэрлэгээ хийх
- Гадна цэвэр усны худагт тат хийх ус буулгагч хийх/ус дулааны худагт/
- Борооны ус зайлуулагдах тагыг томсгох

Зураг төсөл зохиогч байгууллага “АРХЖС” ХХК-ийн гүйцэтгэх захирал

В. Баасанбаатар:

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах хүсэлтэй байна.

АЛТЫН

Ашиглах
ЯСС

Барилгын ажил гүйцэтгэгч "Нью план" ХХК-ийн гүйцэтгэх захирал **Ж.Дорждагва**:

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах хүсэлтэй байна.

Захиалагч Иргэн **Б.Лхагвасүрэн**:

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах хүсэлтэй байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **А.Мөнгөн**:

- Гүйцэтгэгч барилгын тухай хуулийн дагуу чанарын баталгаа ирүүлэх (14.3, 14.6)
- Гадна тохижилтын ажлыг бүрэн хийж дуусгах
- Авто зогсоолын ажлыг бүрэн дуусгах
- Тоглоомын талбайг ерөнхий төлөвлөгөөний дагуу хийх, /UCS/ хэрхэн төлөвлөх
- Айлуудын цахилгаан, розетка, унтраалга зэрэг дутуу тоноглолуулыг гүйцээх
- Техникийн давхрын 2 өрөөг зориулалтын дагуу ашиглах баталгаа ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Хандгайтын богино ХХК, Иргэн Б.Лхагвасүрэнгийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 20 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 225 айлын орон сууцны барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Захиалагчийн иргэн

(Б.Лхагвасүрэн)

Хандгайтын богино ХХК-ийн
гүйцэтгэх захирал



(Б.Лхагвасүрэн)